



КРЕДИТ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН  
ББСБ ХУРЛЫН ТОГТООЛ

2021 оны 6 сарын 23-ны өдөр

№ 2021/23-1

Улаанбаатар хот

Нээлттэй бонд гаргах,  
барьцаа хөрөнгө тогтоох тухай

Монгол улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.5. 76.1.18 дахь хэсэг, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 6 сарын 23-ны өдрийн эчнээ хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Компанийн эргэлтийн хөрөнгийг нэмэгдүүлэх зорилгоор Хавсралт 1-д заасан үнийн дүн, хэмжээ, хугацаа бүхий 5,000,000,000 (таван тэрбум) төгрөгийн нээлттэй бонд гаргахыг зөвшөөрсүгэй.
2. Нээлттэй бонд гаргах болсонтой холбогдуулан үндсэн андеррайтерийн компаниар Голомт Капитал ҮЦК ХХК, туслах андеррайтерийн компаниар Ард Секюритиз ҮЦК ХХК-г сонгон андеррайтерийн гэрээ байгуулж, холбогдох төлбөр тооцоог хийж гүйцэтгэхийг Гүйцэтгэх захирал (Г.Тэлмэн)-д даалгасугай.
3. Туслах андеррайтерийн компанийг сонгон шалгаруулах санал хураалтад сонирхлын зөрчилтэй этгээдүүд оролцоогүй болохыг дурьдсугай.
4. Нээлттэй бондын барьцаанд Ард Санхүүгийн Нэгдэл ХК өөрийн эзэмшлийн Ард Кредит ББСБ ХК-ийн 50,000,000 (Тавин сая) ширхэг энгийн хувьцааг барьцаалуулах тухай холбогдох шийдвэрийг баталгаажуулж авахыг Гүйцэтгэх захирал (Г.Тэлмэн)-д даалгасугай.
5. Тогтоолын хэрэгжилтийг хангуулж, барьцааны гэрээ байгуулан, холбогдох төлбөр тооцоог хийж гүйцэтгэх, нээлттэй бонд гаргах ажлыг зохион байгуулахыг Гүйцэтгэх захирал (Г.Тэлмэн)-д даалгасугай.
6. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 6 сарын 14-ний өдрийн 2021/23 тоот тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.
7. Энэхүү тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дэргэдэх Дотоод Аудитын Хороонд үүрэг болгосугай.

ДАРГА



Ч.ГАНХУЯГ

1. БОНДЫН ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

Хугацаа	18 сар	24 сар
Хүү	13.5%	14.0%

Үнэт цаасны төрөл	Нээлттэй өрийн бичиг (бонд)
Бондын нэрлэсэн үнэ	100,000 (нэг зуун мянган) төгрөг
Олон нийтэд санал болгох тоо	50,000 (тавин мянган) ширхэг
Купон төлөлт	Хагас жил тутам
Үндсэн төлөлт	Хугацааны эцэст
Нийт босгох бондын дүн	5,000,000,000 (таван тэрбум) төгрөг
Бондын бүртгэл	Монголын Хөрөнгийн Бирж болон Монголын Үнэт Цаасны Бирж
Бондын арилжаа	Олон нийтэд
Бондын зарцуулалт	Компанийн эргэлтийн хөрөнгө, зээлийн үйл ажиллагаа
Бондын эргэн төлөлтийн эх үүсвэр	Зээлийн эргэн төлөлтийн үндсэн төлбөр болон хүүгийн орлого
Нийтэд санал болгох хугацаа	2021 оны 3 дугаар улирал (Зохихуулагч байгууллагуудаас шалтгаалан өөрчлөгдөх боломжтой)
Бондын нөхцөл	Эргэн дуудах нөхцөлтэй байх